



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 9/228

Хэрлэн сум

Сургалтад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын даргын 2022 оны 191 дүгээр захирамж, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сангийн яамнаас 2023 оны 3 дугаар сарын 24-өөс 2023 оны 3 дугаар сарын 25-ны өдрүүдэд зохион байгуулсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын нэгдсэн системийн нэвтрүүлэлтийг хэрэгжүүлэх чадавх бэхжүүлэх” зүүн бүсийн сургалт, арга хэмжээнд 2,120,000 (хоёр сая нэг зуун хорин мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.


2. Зарцуулах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

3. Шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны  
... дугаар сарын ...-ны өдрийн  
... дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Үнэ	Нийт дүн
1	Хоол	80 хүн	26,500	2,120,000
	Нийт			2,120,000